

**“СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ХЭМЖЭЭГ БАТЛАХ ТУХАЙ” УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ТАЛААР ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНООС ГАРГАСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2016 оны 08 дугаар
сарын 25-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Б.Ундармаа

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүдээ,

Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны ээлжит сонгуульд Сонгуулийн ерөнхий хороогоор дамжуулан санхүүжигдэх зардлын хэмжээг 13,9 тэрбум төгрөг байхаар тогтоох тухай саналаа Сонгуулийн ерөнхий хороо 2016 оны 08 дугаар сарын 10-ны өдөр Улсын Их Хуралд ирүүлсэн.

Төрийн байгуулалтын байнгын хороо 2016 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаараа дээрх саналыг хэлэлцээд дараах санал, дүгнэлт, Улсын Их Хурлын тогтоолын төслийг нэгдсэн хуралдаанд оруулж байна.

Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны ээлжит сонгуулийг зохион байгуулахад шаардлагатай зардал болох 13,9 тэрбум төгрөгийг Сонгуулийн ерөнхий хорооны батлагдсан төсвөөс 6,6 тэрбум төгрөгийг, Монгол Улсын Их Хурлын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны ээлжит сонгуульд батлагдсан зардлаас хэмнэгдсэн 1,5 тэрбум төгрөгийг, Монгол Улсын 2016 оны Төсвийн тухай хуулиар Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны ээлжит сонгуулийг зохион байгуулахаар аймаг, нийслэл, сум, дүүрэгт хуваарилсан зардлаас 5.8 тэрбум төгрөгийг тус тус нэгтгэн төвлөрүүлж шийдвэрлэхээр тусгалаа.


Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцсон Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч байсан бөгөөд санал гараагүй болно.


Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи нь “Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны ээлжит сонгуулийн зардлын хэмжээг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулах нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Сонгуулийн зардлын хэмжээг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, тогтоолын төслийг баталж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА**  **Н.ЭНХБОЛД**



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ

2016 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар...

Улаанбаатар
хот

Сонгуулийн зардлын хэмжээг батлах тухай

Сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны ээлжит сонгуульд Сонгуулийн ерөнхий хороогоор дамжуулан санхүүжигдэх зардлын хэмжээг 13,904,601,571.0 /арван гурван тэрбум есөн зуун дөрвөн сая зургаан зуун нэг мянга таван зуун далан нэг/ төгрөг байхаар тогтоосугай.

2. Энэ тогтоолын 1-д заасан зардлыг дараахь байдлаар Сонгуулийн ерөнхий хорооны төсөвт нэгтгэн төвлөрүүлэх арга хэмжээ авахыг Монгол Улсын Засгийн газар /Ж.Эрдэнэбат/-т даалгасугай:

1/Сонгуулийн ерөнхий хорооны батлагдсан төсвөөс 6,6 тэрбум төгрөгийг;

2/Монгол Улсын Их Хурлын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны ээлжит сонгуулийн батлагдсан зардлаас хэмнэгдсэн төсвөөс 1,5 тэрбум төгрөгийг;

3/Монгол Улсын 2016 оны Төсвийн тухай хуулиар Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны ээлжит сонгуулийг зохион байгуулахаар аймаг, нийслэл, сум, дүүрэгт хуваарилсан зардлаас 5.8 тэрбум төгрөгийг.

3. Энэхүү зардлыг Сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсэгт заасны дагуу зарцуулахыг Сонгуулийн ерөнхий хороо /Ч.Содномцэрэн/-д зөвшөөрсүгэй.

4. Энэ тогтоолыг 2016 оны 08 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг